

/СХЗГ-ын 2014.12.09-ний А/384-р хүчингүй болгосон/

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ /Улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн жагсаалт/

2008 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 06

“Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай”
Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 8
дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын баталгаажуулалтад заавал
хамрагдах хэмжих хэрэгслийн жагсаалт,
баталгаажуулалт хоорондын хугацаа, нэгж
хэмжүүр шалгах хугацааны нормыг
хавсралтаар баталсугай.

2. Хууль эрхийн хэмжилзүй, эталоны газар
/З.Ганболд/-т даалгах нь:

а/ Улсын баталгаажуулалтад заавал
хамрагдах хэмжих хэрэгслийн жагсаалтын
мөрдөлтөд байнгын хяналт тавьж, аж ахуйн
нэгж, байгууллагыг арга зүйн зөвлөмжөөр
хангаж ажиллах.

б/ Уг жагсаалтын нэгж хэмжүүр шалгах
хугацааны нормыг 2008 онд шинэчлэх арга
хэмжээний төлөвлөгөө батлуулан
хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга
хэмжээ авах.

3. Энэхүү тушаалыг Засгийн газрын 2003
оны 8 дугаар тогтоолд заасны дагуу Хууль
зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх
ажлыг зохион байгуулахыг Төрийн захиргаа,
удирдлагын газар /П.Тунгалаг/-т үүрэг
болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан
төвийн даргын 2007 оны 69 дугаар тушаалыг
хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Г.ГАНТӨМӨР

Улсын бүртгэлд 2008 оны 10 дугаар сарын
3-ны өдрийн 2946 дугаарт бүртгэсэн